



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР**

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа,

Утас/Факс: (976) 7013 3458,

И-мэйл: foreignrelations@immigration.gov.mn,

Вэбсайт: www.immigration.gov.mn

2019.06.19 № 01/1164

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Гадаадын иргэн, харьяатын газрын /төвлөрүүлэн захирагчийн/ 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА



Д.МӨРӨН

Гадаадын иргэн, харьяатын газрын
2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
.../.../... албан бичгийн хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2019 оны 06 дугаар сарын 17

Улаанбаатар хот

№	Илэрсэн зөрчил	Аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлага	Зөвлөмжийн хүрээнд хийгдэх ажил	Зөвлөмжийн биелэлт
1	2	3	4	5
1	Албан шаардлага: Холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн харьяатын газар нь Замын-Үүд сумын Засаг даргын 2017 оны А/378, А/377, А/41, А/327 тоот захирамжуудаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд 288.0 сая төгрөгийн 8 ширхэг автомашин, 2018 онд 198.0 сая төгрөгийн 1 ширхэг Ландкрузер-200 авто машиныг тус тус худалдан авч Гадаадын иргэн харьяатын газар буюу төв байгууллагадаа шилжүүлсэн байна Уг автомашинуудыг худалдаж авах, бүртгэх тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээс данс бүртгэлд тусгаагүй, 5 автомашиныг харьяа газруудад хуваарилан шилжүүлсэн байна.	1.Дээрх автомашинуудыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу авч данс бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах 2. Албан шаардлагын биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гадаадын иргэн, харьяатын газрын	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2017 онд авсан 8 ширхэг автомашин, 2018 онд 1 ширхэг Ландкрузер-200 авто машиныг тус тус ГИХГ-т шилжүүлэх Дорноговь аймагийн ИТХ-ын тогтоолыг гаргуулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт саналыг хүргүүлж, үндсэн хөрөнгөнд бүртгэх тогтоол гаргуулж зөрчлийг	Дорноговь аймагийн Замын-Үүд сумын Засаг даргын 2017 оны А/378, А/377, А/41, А/327 тоот захирамжуудаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 оны 12 дугаар сард 288.0 сая төгрөгийн 8 ширхэг автомашин, 2018 онд 198.0 сая төгрөгийн 1 ширхэг Ландкрузер-200 авто машиныг тус тус хүлээн авсан. 2018 онд Гадаадын иргэн, харьяатын газар болон харьяа газруудын данс бүртгэлд тусгах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт саналаа албан бичгээр хүргүүлсэн байсан бөгөөд балансаас балансад шилжүүлэх талаар Дорноговь аймагийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гараагүй шалтгаанаар үндсэн

1	2	3	4	5
	<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах. Захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж. Энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө. Өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах. Бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон хөрөнгө олж авбал тухай бур Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт мэдэгдэж. Уг хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.</p>	<p>дарга Д.Мөрөн, Санхүү, хангамж үйлчилгээний газрын дарга, ахлах нягтлан бодогч Б.Даваажав нарт даалгав.</p>	<p>Давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авах.</p>	<p>Хөрөнгөнд бүртгэх зөвшөөрөл гараагүй байсан. Гадаадын иргэн, харьяатын газарт дээрх авто машинуудыг "Балансаас балансад шилжүүлэх тухай" Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 04-р сарын 08-ны өдрийн 27 дугаар тогтоол гарсны дагуу балансаас балансад шилжүүлэн авах зөвшөөрлийг хүсэж Газрын даргын 2019 оны 04-р сарын 15-ны №01/694 тоот албан бичгийг хүргүүлсэн одоогоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол гараагүй хүлээгдэж байна. Биелэлт 50%</p>

1	2	3	4	5
1	<p>Байгууллагын дотоод журамд жилийн эцсийн ажлыг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох хувь хэмжээг тодорхой тусгаагүйгээс тайлант жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас 70.0- 80.0 хувиар тооцож, хавтгайруулан олгосноос, үр дүнгийн урамшуулалд нийт 54.4 сая төгрөгийг зарцуулсан байна /нийт 110 орон тоотой ба 107 хүнд үр дүнгийн урамшууллыг олгосон/. Мөн үр хаагчид улирлын ажлын нь үр дүнгээр албан чадварын нэмэгдлийг сар бүр 25 хувиар 76 хүнд хавтгайруулан жилийн дүнгээр 48.3 сая төгрөгийг олгосон байна. - Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад ". төрийн албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно. Албан хаагчийг тийнхүү шагнаж урамшуулах үзүүлэлт, журмыг төрийн тухайн байгууллага боловсруулж хэрэгжүүлнэ" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.</p>	<p>Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэх</p>	<p>2019 онд байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд жилийн эцсийн ажлыг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох хувь хэмжээг Засгийн газраас баталсан тогтоолд нийцүүлэн тодорхой тусгах, мөн үр чадварын нэмэгдлийг бодитоор дүгнэх, түүнтэй холбоотой гарсан тушаал, журмыг мөрдөн ажиллах</p>	<p>"Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 5 дахь заалтад улиралд 40 хүртэлх хувиар урамшуулж болно гэж заасны дагуу ажилтнуудын 3, 4 дүгээр улирлын ажлыг дүгнэн А буюу 90-100, В буюу 80-90 авсан албан хаагчдыг 80 хүртэлх хувиар урамшуулсан тул 3Г-ын тогтоолын дагуу зөрчилгүй олгогдсон. Төрийн албаны тухай хууль өөрчлөгдөн батлагдсантай холбоотойгоор дээрх журмыг Засгийн газраас 2019 оны 5 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд журмын дагуу гүйцэтгэлийн үнэлгээ, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт улирлын ажлын үр дүнг үндэслэн бодитоор дүгнэж олгохоор төлөвлөж байна. Биелэлт 100%</p>
3	<p>Албан шаардлага: 2018 онд APP системийг нэвтрүүлэх програм, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгчээр "Женералтеч ХХК"-ийг сонгож шууд гэрээ байгуулан, тоног төхөөрөмжийн төлбөр 248.5 сая төгрөгийг 100 хувь шилжүүлсэн байна Уг тоног төхөөрөмжийг 2019 оны 1 сарын 10-нд хүлээн авсан тухай акт үйлдсэн боловч өнөөг хүртэл бүртгэлд тусгаж аваагүй байна.</p>	<p>Дээрх системийг нэвтрүүлэх програм, төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгах, зөрчлийг гаргахгүй байх талаар холбогдох арга авч, хэмжээ биелэлтийг</p>	<p>APP системийг нэвтрүүлэх програм, тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд тусгах талаар Төрийн бодлого зохицуулалтын газарт саналыг хүргүүлж зөвшөөрлийг авч бүртгэх.</p>	<p>APP системийг нэвтрүүлэх програм, тоног төхөөрөмжүүдийг өмчийн бодлого зохицуулалтын газарт саналыг хүргүүлсний дагуу 2019 оны 5 дугаар сар 31-ний өдрийн А-4/1618 тоот албан бичгээр үндсэн хөрөнгөнд бүртгэх зөвшөөрөл олгосныг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. Үүнд 61.7 сая төгрөгийн серверийн төхөөрөмжийг тоног төхөөрөмж бүлэгт, 186.7 сая</p>

1	2	3	4	5
<p>- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна</p>	<p>2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p>	<p>Мэдээлэл технологийн хэлтсийн албан хаагчид худалдан авсан болон хандив тусламжаар авсан үндсэн хөрөнгийг санхүүд хүлээлгэн өгөлгүйгээр дур мэдэн хүлээн авахгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авах</p>	<p>төгрөгийн программ хангамжийг программ хангамж бүлэг дээр тус тус орлогод авч бүртгэсэн. Биелэлт 100%</p>	
<p>2018 онд тус байгууллагын даргын А/453 тушаалаар англи хэлний сургалтад 5, А/115 тушаалаар нярав, компьютерийн хавсарсан сургалтад 1 нийт 6 ажилтанд мэргэжлийн бус сургалтуудад хамруулан нийт 3.2 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.</p> <p>- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг мөрдөж ажиллаагүй байна.</p>	<p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах</p>	<p>Үндсэн ажл мөргэжилтэй холбоогүй сургалтуудыг зохион байгуулахгүй байх.</p>	<p>-Төрийн албаны тухай хууль, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Байгууллагын "Албан хаагчдын сургалтын хөтөлбөр /2017-2020/-ийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ажлын зайлшгүй шаардлагаар нийт 5 нь албан хаагчийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх гүнзгийрүүлж сургах зорилгоор англи хэлний сургалтад хамруулсан бөгөөд 2019 оны 1-5-р сарын хугацаанд англи хэлний сургалтад албан хаагчдыг хамруулаагүй. Биелэлт 100%</p>	

1	2	3	4	5
1	<p>Төлбөрийн акт: Тайлант онд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд албан томилолтоор ажилласан албан тушаалтанд аймагт ажиллах томилолтын зардлаар тооцож, томилолтын мөнгийг илүү олгосон, мөн томилолтын хоногийг илүү бодож олгосон зэргээр нийт 2.1 сая төгрөгийг илүү зарцуулсан байна.</p> <p>- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 132 дугаар тушаалын Нэг. ... Улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг суманд 18,000 төгрөг, аймгийн төвд 29,000 төгрөг, Улаанбаатар, Дархан. Эрдэнэт хотод 35,500 төгрөгөөр, төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд зам хоногийн зардлыг суманд 12,000 төгрөг, аймгийн төвд 14,000 төгрөг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод 16,000 төгрөгөөр тус тус тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>	<p>Илүү олгосон томилолтын зардал 2,145,000 төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх арга хэмжээ авч, актын биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх</p>	<p>Тухайн илүү олгосон томилолтын мөнгийг ажилчдаас сууган авч, улсын төсөвт шилжүүлэх</p>	<p>Тухайн илүү олгосон томилолтын мөнгийг албан хаагчдаас сууган авч, улсын төсвийн 100900000601 тоот дансанд 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдөр 2.1 сая төгрөгийг актын төлбөрт шилжүүлсэн. Тушаасан баримтыг хавсаргав. Сангийн яамнаас 2018 оны 301 тоот тушаалаар Дотоод томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсны дагуу томилолтын мөнгийг бодож олгож байна. Биелэлт 100%</p>
6	<p>А. Байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг бүртгэж тайлагнах талаар нэгдсэн бодлого арга зүйгээр хангаж ажиллаагүйгээс ГИХГ-ын харьяа байгууллагуудын зарим нь мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн тайланд тусгасан. зарим нь зөвхөн үр дүнгийн тайлан тусгасан, зарим нь аль ч тайланд тусгаагүй зэргээс шалтгаалан ГИХГ-ын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан дахь үйл ажиллагааны орлого буруу илэрхийлэгдсэн байна.</p>	<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг бүртгэж тайлагнах талаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Үндэсний аудитын газар руу албан бичиг хүргүүлж чиглэл авах</p>	<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар Хууль зүй, дотоод хэргийн яам болон Үндэсний аудитын газар руу албан бичиг хүргүүлж чиглэл авах</p>	<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого /тэмдэгтийн хураамж, хүү торгууль, визийн хуудасны орлого/-ыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар Сангийн яамнаас чиглэл авсан бөгөөд тухайн байгууллагын нэр дээр бүртгэгдэж нээгдсэн дансанд орсон орлогыг санхүүгийн тайлан балансад бүртгэх харин шууд тухайн орон нутгийн харьяаны</p>

1	<p>2</p> <p>Тухайлбал: ГИХГ-ын төв аппарат, ГИХГ-ын агаарын замын боомт хариуцсан газар нь нийт 4,612.7 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд, ГИХГ-ын хойд бүс 96 6 сая төгрөгийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд тус тус тусгаж тайлагнасан бол ГИХГ-ын Дорноговь. Өмнөд бүс, Баруун бүс, Зүүн бүсүүд аль ч тайланд тусгаж, тайлагнаагүй байна.</p> <p>- Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах". Санхүүгийн тайлангийн Үнэн зөв байх" батламж мэдэгдэл, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх" гэж заасныг тус тус мөрдөж ажиллаагүй байна.</p>	3	4	<p>5</p> <p>Төрийн сан, татварын хэлтсийн дансанд орсон орлогыг баланс тайландаа тусгах шаардлагагүй гэж зөвлөсний дагуу бүртгэхээр төлөвлөж байна. Мөн Сангийн яам болон Татварын ерөнхий газраас арилжааны банканд төсвийн орлогын "Тэг" үлдэгдэлтэй дансыг цөөлөх, улс болон орон нутгийн төсвийн орлогыг төрийн сангийн дансанд шууд төвлөрүүлэх, татвар төлөлт, татвар төлөлтийн бүртгэлийг сайжруулах зорилгоор Татварын удирдлагын системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан өгсөн чиглэлийн дагуу манай байгууллага төсвийн орлогын "Тэг" үлдэгдэлтэй данснуудаа 2019 онд хаалгаж орон нутгийн татварын болон төрийн сангаар дамжуулан тухайн орон нутгийн төсөвт шууд төвлөрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Иймд цаашид дээрх орлогуудыг санхүүгийн тайланд тусгах шаардлагагүй болж байна. Биелэлт 100%</p>
---	--	---	---	---

1	2	3	4	5
7	Б. Санхүүгийн нэгтгэсэн тайлан балансыг Сангийн сайдын 2015 оны 12-р сарын 17-ны өдрийн №341-р тогтоолын хавсралтын дагуу гаргаагүй.	Санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан маягтаар гаргах.	2019 оны эхний хагас жил болон жилийн эцсийн тайланг батлагдсан маягтын дагуу гаргах	Гадаадын иргэн, харьяатын газар төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны эхний хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 12-р сарын 17-ны өдрийн 341 дугаар тушаалын хавсралтын дагуу батлагдсан маягтаар гаргахаар төлөвлөж байна. Биелэлт 100%

ХЯНАСАН:


САНХҮҮ, ХАНГАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА



Б.ДАВААЖАВ

НЭГТГЭСЭН:

САНХҮҮ, ХАНГАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
НЯГТЛАН БОДОГЧ



Д.БОЛОРЧУЛУУН